

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 55.020, 67.020

“Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдэг	MNS : 2020
“Food-safe” symbol	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь хүнсний сүлжээний аливаа үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй шууд хүрэлцэх гадаргууг (бүх төрлийн шил, лааз, хуванцар, хатуу цаасан хайрцаг зэрэг сав баглаа боодол, хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний зүйлс, тухайлбал аяга, таваг, халбага, сэрээ, түмпэн, тогоо, торх) хийсэн материалд “хүнстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдэг хэрэглэн, зах зээлд нийлүүлэхэд тавих шаардлагыг тогтооно.

2 Норматив эшлэл

Энэ стандартад Монгол улсын дараах стандартыг эш татсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг хэрэглэнэ. Үүнд:
MNS 1010 : 86, Хүнсний бүтээгдэхүүнд зориулсан хуванцар сав. Ерөнхий техникийн нөхцөл

MNS 5547 : 2005, Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол. Техникийн ерөнхий шаардлага.

MNS 5548 : 2005, Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав, баглаа боодлын шинжилгээний арга

MNS 5580 : 2005, Хуванцар лонхны бэлдэц. Техникийн ерөнхий шаардлага

MNS 5684 : 2006, Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэ баримт бичигт дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

хүнсний сүлжээ

хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;

3.2

хүнстэй хүрэлцэх гадаргуу

бүх төрлийн шил, метал, мод, хуванцар, цаас зэрэг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй шууд хүрэлцдэг сав баглаа боодол, хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмж, ахуйн хэрэгслийг үйлдвэрлэхэд ашигласан материал

3.3

“хүнстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдэг

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй шууд хүрэлцэх гадаргууд ашиглаж буй материалын аюулгүй байдлыг илэрхийлсэн дарсны хундага ба сэрээний дүрслэл бүхий олон улсад ашиглагддаг тэмдэг

3.4

химийн бодисын шилжилт

сав баглаа боодлын материал /хүнстэй хүрэлцэх гадаргуу/-аас химийн аливаа бодис хүнсний бүтээгдэхүүнд нэвчих үйл явц

4 "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдгийг хэрэглэх

4.1 Хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс /машин техник, тоног төхөөрөмж, зoorь, агуулах, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол, ахуйн сав суулга/ нь хүнс болон хүнсний зориулалттай түүхий эдтэй шууд хүрэлцэж, харьцаж байвал түүнийг хүнсстэй харьцах гадаргуу гэж үзнэ.

4.2 Хүнстэй харьцах гадаргууг үйлдвэрлэхэд метал, мод, хуванцар, резин, цаас, төмөр, шил, шаазан, даавуу, цаас гэх мэт янз бүрийн материалыг дангаар буюу хослуулж, мөн цавуу, будагч бодис, өнгө тогтворжуулагч зэрэг туслах бодисыг хэрэглэдэг. Хүнстэй харьцах гадаргууг үйлдвэрлэхэд ашигласан эсхүл түүний бүтцэд агуулагдах химийн бодисын молекулууд нь хоол хүнсстэй шууд харьцаж, хүрэлцэх үед тэдгээрт нэвчиж, шилжсэнээр бохирдуулах эрсдэлтэй байдаг.

4.3 Хүнстэй харьцах гадаргууд ашиглаж буй материалын аюулгүй байдлыг илэрхийлэхэд дарсны хундага ба сэрээний дүрс бүхий "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" олон улсын тэмдгийг (Зураг 1-ийг үзнэ үү)-г хэрэглэнэ.

4.4 "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдэг нь дараах агуулгыг илэрхийлнэ:

- хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй шууд хүрэлцэж буй гадаргуугаас ямар нэг химийн хорт бодис ялгарч, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанар, амт, үнэрт нөлөөлөхгүй.
- тухайн бүтээгдэхүүнийг зааврын дагуу хэрэглэж ашиглахад түүнийг хадгалж, савласан материалын гадаргуугаас стандартаар тогтоосон шилжилтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү бодис хүнсний бүтээгдэхүүнд нэвчиж химийн бохирдол үүсгэхгүй¹.

4.5 "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдэг нь тухайн сав баглаа боодолд савласан хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг огт илэрхийлэхгүй бөгөөд зөвхөн хүнсстэй хүрэлцэж, харьцаж буй материалын аюулгүй байдлыг илэрхийлнэ.

4.6 Хүнстэй харьцах гадаргуу, эсхүл сав баглаа боодлын материалыг хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэх тохиолдол бүрт сав баглаа боодол /хүнстэй харьцах гадаргуу/ эсхүл шошгын хялбар харагдах хэсэгт "хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" гэсэн бичвэр, эсхүл 1-р зурагт үзүүлсэн "хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдгийг тод, ойлгомжтой, арилахааргүй хэлбэрээр байршуулсан байна.


¹ ЕХ-ны улсад 1 dm² хүнсстэй харьцах материалаас 10 микрограммаас ихгүй химийн бодис нэвчихийг зөвшөөрч, ерөнхий хэмжээг тогтоосон байдаг. Харин нэвчилтийн тусгай хэмжээ нь материалын төрөл, хадгалалтын хугацаа болон температур, хүнсний бүтээгдэхүүний шинж чанар, рН-ийн хэмжээ, бохирдуулагч бодисын хоруу чанар зэргээс хамаарч өөр өөр байдаг.

5 "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдгийн загвар, хэмжээ

5.1 "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдгийн загвар, хэмжээг 1-р зураг болон 1-р хүснэгтэд тус тус заасан болно.

5.2 "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдгийг цагаан суурин дээр хар өнгөөр, суурь өнгө нь хар байх тохиолдолд цагаан өнгөөр эсхүл өнгөгүй суурин дээр товойлгож, тод дүрслэн харуулна.

5.3 5.2-т заасны дагуу байршуулах боломжгүй тохиолдолд дагалдах баримт бичигт тусгасан байна.



Зураг1. "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдгийн загвар

Хүснэгт1. "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй" тэмдгийн хэмжээс*

Төрөл	Хэмжээ (АхБ)	Нягтрал
S	30x30 px	72 dpi
M	60x60 px	300 dpi
L	120x120 px	300 dpi
XL	240x240 px	300 dpi

1 px = 0,02645833 см
1 dpi = 1 инч (25,4мм)-д байх цэгийн тоо

6 Хүнстэй шууд хүрэлцэх гадаргуу, сав баглаа боодлын материалын талаарх мэдээлэл


6.1 Хүнстэй шууд хүрэлцэх гадаргуу эсхүл сав баглаа боодлын материалын оноосон, эсхүл худалдааны нэршил, үйлдвэрлэгч эсхүл борлуулагчийн албан ёсны хаяг, ул мөрийг мөшгих бүртгэлийн дугаарыг шошго, эсхүл дагалдах бичиг баримтад тусгана.

6.2 Хүнстэй хүрэлцэх гадаргуу, эсхүл сав баглаа боодлыг хэрэглэх, хэрэглэсний дараа дахивар болгож, дахин боловсруулах зааврыг өгсөн байна.

Жишээ: Температурын ямар нөхцөлд материалыг ашиглах, ямар төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг савлах (өөх тосны агууламж, хүчиллэг, чийгийн хэмжээ гэх мэт), цэвэрлэгээ, ариутгалын ямар горим хэрэглэх гэх мэт.

6.3 Хуванцар материалыг үйлдвэрлэхэд ашигласан резиний төрлийг таних, дахивар боловсруулах үйлдвэрт хүлээж авахад зориулсан тэмдэглэгээ² нь тухайн материал хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй шууд хүрэлцэхэд аюулгүй гэсэн утгыг огт илэрхийлэхгүй ба үүнийг “Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдэгтэй хамт хэрэглэж болно.

ТӨГСӨВ.

² Хуванцар үйлдвэрлэлийн нийгэмлэгээс 1988 онд боловсруулсан хуванцрын төрлийг тодорхойлох систем бөгөөд дахин боловсруулах боломжийг илэрхийлсэн гурвалжин тэмдэглэгээ дотор 1-ээс 7 хүртэлх цифрээр хуванцрыг үйлдвэрлэхэд ашигласан резиний төрлийг зааж өгдөг. 

Ном зүй:

1. European Commission, Health and consumers directorate-general, Safety of the food chain, chemicals, contaminants, pesticides, "Symbols to label food contact materials" working document, SANCO E3/FV (15 09 2009)
2. <https://www.industrialspec.com/resources/food-contact-material/>
3. Regulation (EC) No. 1935/2004 of the European Parliament and of the Council of 27 October 2004 on materials and articles intended to come into contact with food and repealing Directives 80/590/EEC and 89/109/EEC, Official Journal of the European Union L338, 4-17 (2004)

САНАЛ АВАХ ТӨСӨЛ